

ТӨСӨЛ

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7 дахь хэсэг, 268¹ дүгээр зүйлийн 268¹.1.1 дэх заалт, 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.1 дэх заалт, 270¹ дүгээр зүйлийн 270¹.1.4 дэх заалт, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын ..-ны өдрийн хуралдааны ... дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” 680 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горим хэрэгжүүлэх журам”-ын 2.4 дэх заалтын хүснэгтийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

д	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Шаардах өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Барааг гаалийн баталгаат агуулахаас улс хоорондын тэврийн үйлчилгээнд гаргах	910	700-708
2	Монголын барааг улс хоорондын тээврийн үйлчилгээнд гаргах	911	шаардахгүй
3	Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулсан барааг улс хоорондын тээврийн төлбөртэй үйлчилгээнд гаргах	912	745-747

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавих, харьяа гаалийн газар, хорооны дарга нарт чиглэл хүргүүлэх, гаалийн харилцаанд оролцогчдод сурталчлан таниулж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар /Б.Даваасүрэн/, Хуулийн хэлтэс /Ч.Тамираа/-т тус тус үүрэг болгосугай.

3.Шинээр батлагдсан гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг гаалийн мэдээллийн автоматжуулсан CAIS системийн санд нэмж, оруулахыг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн газар /Б.Ганзориг/-т даалгасугай.

4.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа гаалийн газар, хорооны дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ